



**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2012 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

**Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн томилох тухай**


Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын даргын 2009 оны 08 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн технологийн үндэсний паркийн дүрэм”-ийн 4.1, 4.2, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологийн үндэсний паркийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор томилсугай.

Хоёр. Тус паркийн Удирдах зөвлөлийн даргад Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Энхболдыг дэвшүүлэн хэлэлцүүлэхийг Мэдээллийн технологийн үндэсний паркийн Удирдах зөвлөлд санал болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” 2011 оны 68, “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 2012 оны 78 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЖАДАМБАА

113173

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2012 оны 11 сарын 01 өдрийн 311 дугаар тушаалын хавсралт



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. З.Энхболд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
2. Б.Буян-Өлзий Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны дарга
3. Ч.Лодойравсал МУИС-ийн Мэдээллийн технологийн сургуулийн захирал
4. Б.Нэмэхбаяр Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн
5. В.Баярсайхан Синглтон ХХК-ийн гүйцэтгэх захирал